



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

АУДИТЫН КОД: ӨМА-2022/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533552 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



Нэг. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Татварын хэлтсийн эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэн, татварын албаны 2021 оны үйл ажиллагааны зорилт, Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд татварын асуудлаар тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, татварын сургалт, сурталчилгааны ажлыг өргөтгөж, татварт хамрагдалтын түвшинг дээшлүүлэх, татварын өр барагдуулалтын ажлыг эрчимжүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр нөлөөтэй болгох, хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгон бэхжүүлэх үндсэн дээр улс, орон нутгийн төсвийг жигд ханган биелүүлэхээр 54 хүний бүтэц, орон тоотойгоор зорин ажиллаж байна.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/
Санхүүгийн байдлын тайлан		
	Үзүүлэлт	2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>65.3</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>1,552.2</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>1,617.5</u>
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1,617.5</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,158.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,217.7
	Үйл ажиллагааны үр дүн	-59.3
	Үйл ажиллагааны бус үр дүн	-19.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>-78.3</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,697.4
	Тайлант оны үр дүн	-79.9
	Эцсийн үлдэгдэл	1,617.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>1,127.2</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,102.7
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>24.5</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	24.5
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-24.5
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,014.1
	Урсгал зардал	1,014.1
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,014.1



Улсын төсвөөс санхүүжих	1.014.1
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	

Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлэлд 150 мэдээлэл оруулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 зүгээр зүйлийн 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 7 дугаар зүйлийн 7.1 “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” дахь заалтуудтай нийцэхгүй байна. Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.



Тав. Аудитын үр дүн

5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	7	2,031.3	5	2,030.5			2	0.8		
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	7	2,031.3	5	2,030.5			2	0.8		

5.2 Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 2,031,315.4 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 2,030,501.0 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, дотоод хяналт, бүртгэл сайжруулах 814.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Орлого үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг цалингийн өглөг данстай тулган баталгаажуулахад 426,228.2 төгрөг, өмнөх оны санхүү байдлын тайлангийн бараа материалын дүнг бараа материалын эхний үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад 1,054.0 мянган төгрөг, өмнөх оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн нийт хөрөнгийг, үндсэн хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад 1,571,712.4 төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайланд 30,994.5 мянган төгрөгийн төвлөрүүлсэн шилжүүлгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулах бичилт хийгээгүй зэрэг алдааг аудитын явцад залрууллаа.

Албан шаардлага:

Өмнөх оны аудитаар “ерөнхий журналаас цалингийн өглөг, шатахууны өглөгийг шалгахад дансаа бүрэн татаагүй, зардлын данснууд давхар татагдаж байна” гэсэн зөвлөмжийг хүргүүлсэн боловч хэрэгжээгүй, мөн хагас, бүтэн жилийн хөрөнгийн тооллогын комиссын гишүүдэд илүү цагийн хөлс олгосон зөрчилд тус тус албан шаардлага хүргүүллээ.

Зөвлөмж:

Шилэн дансны цахим мэдээллийн системд 150 мэдээлэл оруулахаас 9 мэдээллийг хоцруулсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.



Зургаа. Аудитын санал дүгнэлт /баталгаажсан хувийг оруулах/



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА С.ДҮҮБАЯР
ТАНАА

2022-02-22 № 118
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 С.ДЭРЭНБАЯР